


САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2012 оны X сар

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ


Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө буурч байна

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 17.3%, өнгөрсөн сарынхаас 0.3% тус тус нэмэгдэж 7.1 их наяд төгрөгт (5.1 тэрбум ам.доллар) хүрчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 3.3% нэмэгдэж, өмнөх сарынхаас 3.8% буурч 0.7 их наяд төгрөг болсон нь нийт мөнгөний 10.1%-ийг эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд гадаад валютын хадгаламжийн өсөлт хамгийн их нөлөөлөв.



Гадаад валютын хадгаламж нэмэгдэж байна


Хадгаламжийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 24.2%, өмнөх сарынхаас 1.8% тус тус нэмэгдэж 4.7 их наяд төгрөгт (3.3 тэрбум ам.доллар) хүрлээ. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 11.3% өссөн бол валютынх 65% өсчээ. Харин өмнөх сарынхтай харьцуулахад төгрөгийн хадгаламж 3% нэмэгдэж, валютын хадгаламж 0.6% буурсан байна. Төгрөгийн ханшийн чангаралт буюу ам.долларын ханшийн уналттай уялдан валютын хадгаламж бага зэрэг буурч эхэллээ.



Зээлийн өрийн үлдэгдэл 6.9 их наяд төгрөг

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 0.2% буурч, өнгөрсөн оны мөн үеэс 31.3% нэмэгдэж, 6.9 их наяд төгрөг (4.9 тэрбум ам.доллар) боллоо.

Чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 11.9% буурч, нийт зээлд эзлэх хувь 4.5% хүрэв. Зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) жилийн өмнөхтэй харьцуулахад төгрөгийнх 2.8, валютынх 1.1 нэгжээр тус тус өсчээ.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Хадгаламжийн хүүнээс татвар авах хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байна.
- > Засгийн газраас 2013 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барилаа.
- > Засгийн газар Монголбанктай хамтран гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.
- > Уул уурхайн яам, Монголбанк, шатахуун импортлогчид гэсэн 3 талын төлөөлөл ирэх 4 жилд шатахууны үнийг тогтвортой байлгах гэрээнд гарын үсэг зурлаа

Хураангуй

Нүүрсний үнэ өнгөрсөн 6 сараас эхлэн унаснаар Монгол Улсын гадаад худалдааны алдагдал огцом нэмэгдэж эхэлсэн. Үүнээс үүдэлтэй төсвийн орлого ч тасалдахад хүрээд байгаа билээ. Тэгвэл тогтвортой байсан зэсийн үнэ өнгөрсөн сард мөн унаж манай улсын гадаад худалдаа болон төсвийн орлогын төлөвлөгөөг улам хүнд байдалд орууллаа. Гадаад худалдааны алдагдал өнгөрсөн сарынхаас өссөн үзүүлэлттэй гарч 2.1 ам.долларт хүрлээ. Үүнд мэдээж манай экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24% буурсан нь голлон нөлөөлсөн байна. Гэвч зэсийн үнийн уналтыг түр зуурынх гэж шинжээчид таамаглажээ. Монголбанк засгийн газар хамтран гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны мөрийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуран, шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах, өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрүүдийг баталлаа. Ингэснээр дунд хугацаанд инфляцийг 1 оронтой тоонд барих эхний алхамууд хийгдэж байгаа ч өнгөрсөн сард инфляци өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15% болж өмнөх сараас 2 нэгжээр өслөө. Инфляци ийн өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөн нь голлон нөлөөлсөн байна. Сүүлийн саруудад ам.долларын эсрэг сулраад байсан төгрөгийн ханш өнгөрсөн сард чангарч 1387 төрөгт хүрлээ. Гэвч энэ чангаралт нь түр зуурынх байх магадлалтай юм. Учир нь манай орны валютын ханшны улирлын мөчлөгөөр шинэ жил, цагаан сар гэх мэт баяруудаар ам.долларын худалдан авалт нэмэгддэг. Энэ нь ам.долларын нийлүүлэлтийг багасгаж ам.доллар үнэд орох боломжтой үе юм. Иймээс ирэх саруудад төгрөгийн ам.доллартай харьцах ханш ахин 1400 хүрэх магадлалтай. Төгрөг ийн бага зэрэг чангарсантай холбоотойгоор өсөлттэй байсан валютын хадгаламж өмнөх сарынхаас 0.6% буурсан үзүүлэлттэй байна.